

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2006 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг тогтоолын нэгдүгээр хавсралтаар, "Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоож, нотлоход баримтлах заавар"-ыг тогтоолын хоёрдугаар хавсралтаар, "Хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн загвар"-ыг гуравдугаар хавсралтаар, "Хоршооны бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж"-ийг дөрөвдүгээр хавсралтаар, "Программ хангамж, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны тодорхойлолт"-ыг тавдугаар хавсралтаар, "Хоршооны үүсгэн байгуулагч, тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хорооны дарга гишүүдийн тодорхойлолтын загвар"-ыг зургадугаар хавсралтаар, "Хоршооны боловсон хүчний тодорхойлолтын загвар"-ыг долдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчлан ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХОРШООНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь дараах нөхцөл, шаардлагыг байнга хангаж ажиллана. Үүнд:

1. Хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд:

1.1.Хоршооны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу үүсгэн байгуулагдан, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байх; (хуулийн этгээдийн чадамжтай болсон)

1.2.Хоршооны гишүүдийн тоо нь Хоршооны тухай хуулийн 48¹.1-д заасан доод хязгаарыг хангасан байх;

1.3. Хоршооны тухай хуулийн 9.2-т заасны дагуу хоршооны дүрмийг баталсан байх; уг дүрэмд Хоршооны тухай хуулийн 5.3, 8.1.2, 8.3, 9.3, 13.2, 14.1.10, 14.1.11, 15.1.5, 16.7, 18.2, 19.4, 22.1, 26¹.2, 26¹.4, 30.2, 35.1.4, 35.1.6, 48.1, 48¹.2, 48².5, 48³.1, 48³.2, 48⁴.4-д заасан асуудлыг бүрэн шийдвэрлэж тусгасан байх; (хоршооны үйл ажиллагаа болон онцлогыг тодруулан тусгасан байна) хоршооны дүрмийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг байх;

1.4.Хоршооны дүрмийн өөрчлөлтийг Хоршооны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хийж, тогтоосон хугацаанд бүртгэх байгууллагад мэдэгддэг байх;

1.5. Хоршооны бүх гишүүдийн хурал, төлөөлөгчдийн хурлыг Хоршооны тухай хуулийн 23, 24, 25, 26, 26¹ дэх зүйлд заасны дагуу тогтмол хуралдуулж, ээлжит хурлаар санхүүгийн тайлан, тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон эрсдэлийн хорооны тайлан, хоршооны үйл ажиллагаа болон ногдол ашиг хуваарилах эсэх, гишүүдийн бүрэн эрхийн асуудлыг хэлэлцдэг байх, холбогдох хууль, тогтоомж, дүрэмд заасны дагуу шийдвэр гаргаж, гарсан шийдвэрийг баталгаажуулж, гишүүд холбогдох шийдвэрүүдтэй хэдийд ч танилцах боломжтой байх;

1.6. Хоршооны тэргүүлэгчээр ял шийтгэлгүй, эсхүл урьд өмнө дампуурсан хоршоонд ажиллаж байгаагүй, банк санхүү, эрх зүйн аль нэгэн чиглэлээр ажлын дадлага, туршлага бүхий гишүүдийг сонгосон байх, хоршооны тэргүүлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, ажил үүргийн хуваарийг нь тодорхой болгосон байх, үйл ажиллагаагаа бүх гишүүдийн хуралд тогтмол тайлагнаж, түүнийг нь дүгнэж, хариуцлага тооцдог тогтолцоог бүрдүүлж хэвшсэн байх, Тэргүүлэгчид нь хяналтын зөвлөл, зээлийн хороо болон

эрсдэлийн хороо, гүйцэтгэх захиралтай нягт хамтран ажилладаг байх, Хоршооны дарга нь тэргүүлэгчдийн дарга байх, нэг гишүүн сонгуульт албан тушаал давхар хашихгүй мөн хоршооны өдөр тутмын буюу гүйцэтгэх ажлыг эрхлэхгүй байх;

1.7. Хоршооны дарга, гүйцэтгэх захирлаар ял шийтгэлгүй, эсхүл урьд өмнө дампуурсан хоршоонд ажиллаж байгаагүй, аливаа санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй, санхүү эдийн засаг, хууль, нягтлан бодох бүртгэл, аудит, бизнесийн удирдлагын аль нэгэн чиглэлээр мэргэшсэн, энэхүү чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан хүнийг сонгосон байх, тэдгээрийн эрх, үүрэг, ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, ажлаа бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлд тайлагнаж, түүнийг нь дүгнэж, хариуцлага тооцдог тогтолцоог бүрдүүлж хэвшсэн байх;

1.8. Хяналтын зөвлөлийг холбогдох хууль, дүрмийн дагуу байгуулсан байх, санхүү, хууль зүйн мэдлэг, чадвар, дадлага, туршлага бүхий, ял шийтгэлгүй, урьд өмнө дампуурсан хоршоонд ажиллаж байгаагүй гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр сонгосон байх, хоршооны үйл ажиллагааг нь тогтмолжуулж, зөвлөл, түүний гишүүдийн эрх үүрэг, ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, ажлын үр дүнг бүх гишүүдийн хуралд тайлагнадаг байх, Хоршооны дарга, тэргүүлэгчид, гүйцэтгэх захиралд мэдээлдэг, түүнийг нь дүгнэж, хариуцлага тооцдог тогтолцоог бүрдүүлж хэвшсэн байх;

1.9. Хоршооны зээлийн хороо буюу Эрсдэлийн хороог хуульд заасан журмын дагуу байгуулсан байх, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль зүйн мэдлэг, чадвар, дадлага туршлага бүхий, ял шийтгэлгүй, аливаа санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй, урьд өмнө дампуурсан хоршоонд ажиллаж байгаагүй гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, хороо, түүний гишүүдийн эрх үүрэг, ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, ажлын үр дүнг бүх гишүүдийн хурал, Хоршооны дарга, тэргүүлэгчид, хяналтын зөвлөлд тайлагнадаг, ажлыг нь дүгнэх, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлж хэвшсэн байх, Хадгаламж зээлийн мэргэжилтэн мөнгөний няравын албыг зэрэг хашихгүй байх;

1.10. Хоршоонд шинээр гишүүн элсүүлэхдээ Хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу элсүүлсэн байх, шинээр гишүүн элсүүлэхэд улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийг, холбогдох бусад хүчин төгөлдөр мөрдөж буй журам, санхүүгийн байдлын талаарх мэдээлэлтэй танилцуулж, тэдгээрийг хүлээн зөвшөөрсөн эсэх талаар тодорхойлолт гаргуулдаг байх;

1.11. Хоршооны гишүүдийн бүртгэлийг Хоршооны тухай хуулийн 29.2-т заасны дагуу хөтөлсөн байх, гишүүдийн бүртгэлд гишүүдийн гарын үсгийн баталгаажуулсан хуулбарыг хавсаргадаг байх, бүртгэлд орсон өөрчлөлтийг Хоршооны тухай хуулийн 11.4-т заасны дагуу бүртгэх байгууллагад мэдэгдэж бүртгүүлдэг байх;

1.12. Хоршооны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлтэй гишүүд хэдийд ч танилцах боломжийг бүрдүүлсэн байх, гишүүдээс гаргасан үндэслэл бүхий

санал, шүүмжлэлийг хүлээн авч, тухай бүр шуурхай шийдвэрлэж хариу өгч, үр дүнг тэргүүлэгчдийн хурал, бүх гишүүдийн хуралд танилцуулдаг байх горимыг тогтоон мөрдүүлж хэвшсэн байх;

1.13. Хорооны зүгээс тавьсан шаардлага, мэдэгдлийг тогтоосон хугацаанд түргэн шуурхай гүйцэтгэж, хууль бус, эрсдэл бүхий үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр Хороотой хамтарч ажилладаг байх;

1.14. Үйл ажиллагаа явуулах ажлын байртай, албан ёсны хаягтай байх;

1.15. Мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг ханган ажилладаг байх.

2. Санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой, эрсдэлгүй байдлыг хангах ажиллагааны хүрээнд:

2.1. Хоршоо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагааг эрсдэлгүй, алдагдалгүй, явуулах чиглэлээр үндэслэл бүхий бизнес төлөвлөгөөг боловсруулсан байх, уг төлөвлөгөөг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгодог байх;

2.2. Иргэний хуулийн 33.2-т заасны дагуу ашгийн бус зарчмыг холбогдох төлөвлөгөө, үйл ажиллагаандаа тусгаж, мөрдлөгө болгодог байх, Хадгаламжид төлөх хүү, олгосон зээлийн хүүгийн хэмжээ нь хоршооны эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдоогүй байх;

2.3. Хоршооны нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын зарчимд нийцсэн байх, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сар бүр хангаж ажилладаг байх, хангахгүй болсон буюу хангахгүй болж болзошгүй тохиолдолд энэ талаар тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон эрсдэлийн хороонд даруй мэдэгддэг байх, тэдгээр нь шуурхай арга хэмжээ авч уг нөхцөл байдлыг дараа сарын дотор залруулах боломжгүй бол бүх гишүүдийн хурлаар асуудлыг хэлэлцүүлдэг журмыг тогтоон хэвшүүлсэн байх, үүнтэй холбоотой мэдээлэлтэй гишүүд хэдийд ч танилцах боломжийг бүрдүүлсэн байх;

2.4. Хоршооны тухай хуулийн 49.1.3 дахь заалтыг ханган ажиллахдаа хадгаламж авах, зээл олгох үйл ажиллагааг зөвхөн гишүүдийнхээ хүрээнд явуулдаг байх, гишүүдээс төвлөрүүлсэн хадгаламж, хоршооны өөрийн хөрөнгөөс зээлийн эх үүсвэрт ашиглах хөрөнгийг хоршооны бусад хөрөнгөөс тусгаарлан, тэдгээр хөрөнгийг хадгаламж, зээлийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаанд зарцуулдаггүй байх; (“гишүүдийн хүрээнд хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх” гэдэгт Хоршооны тухай хуулийн 48².6-д заасны дагуу хоршооны гишүүний насанд хүрээгүй хүүхдийн нэр дээр нээлгэсэн хадгаламж хамаарахгүй)

2.5. Ямар нэг хэлбэр, аргаар гишүүн бус этгээдээс хадгаламж авах, гишүүн бус этгээдэд зээл олгодоггүй байх (тухайлбал, гишүүний эхнэр, нөхөр, аав,

ээж, ах, дүү, төрөл садангийн болон найз зэрэг тухайн гишүүний насанд хүрээгүй хүүхдийн нэр дээр хадгаламж нээхээс бусад холбоотой хүмүүс, эсхүл гишүүнээр элсээгүй буюу гишүүний эрх нь нээгдээгүй иргэн, хуулийн этгээд), олгох боломж, нөхцөлийг таслан зогсоосон байх;

2.6. Нэг гишүүнээс авч болох хадгаламж, нэг гишүүнд олгож болох зээлийн хэмжээг (энд “нэг гишүүнээс авч болох хадгаламж, олгож болох зээл”-ийн хэмжээг тухайн нэг гишүүнд нэг буюу хэд хэдэн хэлцлийн үндсэн дээр авсан хадгаламж, эсхүл олгосон нийт зээлийн хэмжээгээр тооцно) тухайн хоршооны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нөлөөлөхөөргүй хэмжээгээр тогтоож, уг хэмжээнээс хэтэрсэн хадгаламжийг нэг гишүүнээс авдаггүй буюу нэг гишүүнд зээл олгодоггүй байх, гишүүн хоршоонд оруулсан хөрөнгийг барьцаалан зээл авахгүй байх, гишүүн хадгаламжийн дансаа барьцаалан зээл авсан бол нийт үүргийн гүйцэтгэлийн хэмжээгээр уг хадгаламжийн дансны гүйлгээг хязгаарлаж байх;

2.7. Тодорхой гишүүнд олгох зээл нь түүний хадгалуулсан хөрөнгийн хэмжээнээс давсан бол уг давсан хэмжээнд заавал барьцаа, эсхүл батлан даалтын гэрээ байгуулдаг байх;

2.8. Гаднаас оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тухайн хоршооны санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлөхөөргүй хэмжээгээр бүх гишүүдийн хурал, эсхүл бүх гишүүдийн хурлын эрх олгосноор тэргүүлэгчдийн хурлаас тогтоосон байх, уг хязгаарыг чанд баримтлан ажилладаг байх;

2.9. Санхүүгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрхэлдэг байх, зээлийн багцыг холбогдох журмын дагуу ангилж, зээлийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй алдагдлыг нөхөх эрсдэлийн санг бүрэн хэмжээнд байгуулдаг байх, зээлийн эргэн төлөлтөд өдөр тутам хяналт тавьж, шуурхай төлүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх бүтэц, журмыг боловсруулан баталсан байх;

2.10. Үйл ажиллагаанаас учирч болзошгүй алдагдал буюу эрсдэлийг даатгуулсан байх;

2.11. Улирал бүр санхүүгийн тайлан, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг дараа сарын 10-ны дотор, хөндлөнгийн аудитын баталгаажуулсан санхүүгийн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор тус тус Хороонд ирүүлсэн байх, гишүүд тэдгээр тайлантай хэдийд ч танилцах боломжийг бүрдүүлсэн байх;

2.12. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохицуулалт үйлчилгээний хөлсийг тухай бүр хугацаанд нь төлдөг байх.

3. Нөхцөл, шаардлага хангасан болохыг нотлох баримт бичгийн хүрээнд:

3.1. Албан бичгийн шаардлагыг хангасан, зөрчилгүй, үг үсгийн алдаагүй байх;

3.2. Бүрэн бүрдэл бүхий шаардлага хангасан баримт бичгийг нэгтгэж, нүүр бүрээр дугаарлаж, товъёолсон байх;

3.3 Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хоршооны дүрэм, хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны журмын улсын бүртгэлд бүртгэгдсэн хүчин төгөлдөр хувийг нотариатаар гэрчлүүлсэн байх;

3.4. Бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчид, хоршооны дарга, гүйцэтгэх захирал, зээлийн хорооны шийдвэрийг баталгаажуулсан байх, хуулбарлан ирүүлэх бол хуулбар үнэн болохыг гэрчлүүлсэн байх;

3.5. Их хэмжээний хэлцлийн талаар гаргасан шийдвэрийг тэмдэглэлийн хамтаар ирүүлэх, тэдгээрийг хуулбарлан ирүүлэх бол хуулбар үнэн болохыг гэрчлүүлсэн байх;

3.6. Санхүүгийн баримт, тайлан мэдээг тогтоосон хэлбэр, загварын загуу үнэн зөвөөр гаргаж ирүүлэх.

Хоёр. Энэхүү хавсралтын нэгд дурдсан нөхцөл, шаардлагыг хангасан хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны шийдвэрээр олгоно.

Гурав. Энэхүү хавсралтын нэгд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй үйл ажиллагаа нь тухайн хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно.

---oOo---

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХОРШООНЫ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХИЙГ
ТОГТООЖ, НОТЛОХОД БАРИМТЛАХ ЗААВАР**

Энэхүү зааврыг хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоож, нотлоход баримтлана.

Дугаар	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох байдал
1. Хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд:		
1.1	Хоршооны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу үүсгэн байгуулагдан, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байх; (хуулийн этгээдийн чадамжтай болсон)	1. Улсын бүртгэлийн гэрчилгээг авсан, (хүчин төгөлдөр) 2.Хоршооны дүрмийг Улсын бүртгэлийн албанд хянуулж, хуудас бүрийн баталгаажуулсан, 3.Хоршоог үүсгэн байгуулах бичиг баримт нь хууль тогтоомж зөрчөөгүй, үүсгэн байгуулах ажиллагааг зохих журмын дагуу хийж, тогтоосон хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлсэн болохыг нотлосон байна. Шаардлагатай гэж үзвэл уг асуудлаар ҮТЕГ-ын харьяа Улсын бүртгэлийн албанаас тодорхойлолт, лавлагаа авах, баримтын тулгалт хийж болно.
1.2	Хоршооны гишүүдийн тоо нь Хоршооны тухай хуулийн 48 ¹ .1-д заасан доод хязгаарыг хангасан байх;	Хоршоо нь 20-иос доошгүй гишүүнтэй байх бөгөөд Улсын бүртгэлийн гэрчилгээнд дурдсан гишүүдийн тоо буюу улсын бүртгэлд бүртгүүлсэн гишүүдийн тоо нь тухайн хоршооны үйлчилгээнд хамрагдсан эрх бүхий гишүүдийн тоо эсвэл хоршооны гишүүдийн бүртгэлд бүртгэлтэй гишүүдийн тоотой нийлж байгаа эсэхийг тогтооно.
1.3	Хоршооны тухай хуулийн 9.2-т заасны дагуу хоршооны дүрмийг баталсан байх;	1.Хоршооны дүрмийг бүх гишүүдийн хурлаар батлахад гишүүд бүрэн хамрагдсан болохыг нотолж хуралд оролцсон гишүүдийн овог, нэр, оршин суух болон холбоо барих хаяг, иргэний үнэмлэх, регистрийн дугаарын

	<p>Дүрэмд Хоршооны тухай хуулийн 5.3, 8.1.2, 8.3, 9.3, 13.2, 14.1.10, 14.1.11, 15.1.5, 16.7, 18.2, 19.4, 22.1, 26¹.2, 26¹.4, 30.2, 35.1.4, 35.1.6, 48.1, 48¹.2, 48².5, 48³.1, 48³.2, 48⁴.4-д заасан асуудлыг бүрэн шийдвэрлэж тусгасан байх; (Хоршооны үйл ажиллагаа болон онцлогыг тодруулан тусгасан байна)</p> <p>Хоршооны дүрмийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг байх;</p>	<p>бүртгэлийг хийсэн эсэхийг тогтооно,</p> <p>2.Хурлын тэмдэглэлд хурал хуралдсан огноо, байршил, гишүүд хуралд биечлэн, эсхүл бусад хэлбэрээр хэрхэн оролцож, хэрхэн санал өгсөн, асуудал тус бүрийн хэлэлцсэн тухай дэлгэрэнгүй тэмдэглэл болон биеээр оролцсон гишүүдийн гарын үсэг байгаа эсэхийг тогтооно ,</p> <p>3.Хурлаас гарсан шийдвэрийг тогтоолоор баталгаажуулсан эсэхийг тогтооно,</p> <p>4.Хоршооны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хоршоо нь дүрэмд заавал заахаар (шууд гипотези) буюу хоршооны гишүүд хуульд зааснаас өөрөөр зааж болохоор (сонгох гипотези) асуудлуудыг нэгбүрчлэн, бүрэн шийдвэрлэж дүрмэндээ тусгасан байх (тухайлбал: Бүх гишүүдийн хурлын эрх хэмжээ болон хурлын санал хураах зарчмыг тодорхойлох, газар зүйн байршил болон тухайн аж ахуйн нэгж байгууллагад харъяалагдах ажиллагсад, оюутан, гэр бүлийн гишүүдийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг онцлон тусгах, гишүүдээс хоршоонд оруулах хувь хөрөнгийн дээд, доод хэмжээ, хөрөнгийг буцааж олгох нөхцөл, шаардлага, хязгаарлалт, маргаан шийдвэрлэх нөхцөл, хариуцлага, хоршооны эд хөрөнгийн бүх гишүүдийн хурлаас баталсан зориулалтаас өөр зүйлд зарцуулахгүй, зээлдүүлэхгүй байх, хоршоо алдагдалтай ажилласан бол хэрхэн нөхөх журам, зардлын төсөв батлах, хоршооны зээлийн сангийн хөрөнгийг зөвхөн хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд зарцуулах, хадгаламж дахь хөрөнгийг хоршооны зээлийн сангаас бусад сангийн хөрөнгөтэй хутгахгүй байх гэх мэт) бөгөөд үүнийг хурлын тэмдэглэлд үндэслэн тогтооно.</p> <p>Шаардлагатай гэж үзвэл уг асуудлаар бүртгэлийн албанаас тодорхойлолт, лавлагаа авах, баримтын тулгалт хийж болно.</p> <p>Дүрэмд тухайн хоршооны тэргүүлэгчид, хяналтын хороо, зээлийн хорооны гишүүд, дарга, гүйцэтгэх захирал болон ажилтнуудын зүгээс сонирхолын зөрчил бүхий хэлцэл хийхээс сэргийлсэн, хориглосон зохицуулалт тусгасан эсэх, гишүүдийн хяналт, тэдгээрийн эрх ашиг зөрчигдөхөөс хэрхэн хамгаалсан</p>
--	---	--

		<p>талаарх зохицуулалтыг дүрмийн заалтаас нягтлан тогтооно.</p> <p>Хадгаламж, зээлийн үйл ажиллагаанаас бусад Хоршоо эрхэлж үл болох санхүүгийн үйл ажиллагаа явуулахаар дүрэмд заагаагүй, тийм үйл ажиллагаа явуулаагүй болохыг дүрэм, холбогдох баримт бичгийг үндэслэн тогтооно.</p>
1.4	<p>Хоршооны дүрмийн өөрчлөлтийг Хоршооны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хийж, тогтоосон хугацаанд бүртгэх байгууллагад мэдэгддэг байх;</p>	<p>Өмнөх дүрмэндээ өөрчлөлт оруулсан бол уг өөрчлөлтийг Хоршооны тухай хуульд заасны дагуу бүх гишүүдийн хурлаар хэлэлцсэн, шийдвэр гаргасан байх, уг шийдвэр нь агуулгын хувьд холбогдох хууль тогтоомжид нийцсэн, зөрчилгүй байх, уг өөрчлөлтийн талаар улсын бүртгэлийн албанд хуульд заасан хугацаанд багтаан мэдэгдсэн болохыг тогтооно. Шаардлагатай гэж үзвэл уг асуудлаар бүртгэлийн албанаас тодорхойлолт, лавлагаа авах, баримтын тулгалт хийж болно.</p>
1.5	<p>Хоршооны бүх гишүүдийн хурал, төлөөлөгчдийн хурлыг Хоршооны тухай хуулийн 23, 24, 25, 26, 26¹ дэх зүйлд заасны дагуу тогтмол хуралдуулж, ээлжит хурлаар санхүүгийн тайлан, тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон эрсдэлийн хорооны тайлан, хоршооны үйл ажиллагаа болон ногдол ашиг хуваарилах эсэх, гишүүдийн бүрэн эрхийн асуудлыг хэлэлцдэг байх, холбогдох хууль, тогтоомж, дүрэмд заасны дагуу шийдвэр гаргаж, гарсан шийдвэрийг баталгаажуулж, гишүүд холбогдох шийдвэрүүдтэй хэдийд ч танилцах боломжтой байх;</p>	<p>Бүх гишүүдийн ээлжит хурлыг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу тогтмол хийж, хэлэлцвэл зохих асуудлыг бүрэн хэлэлцдэг (хэрэв төлөөлөгчдийн хуралтай бол уг хурлаар), хурлаар гишүүдийн бүрэн эрхийн асуудал, хоршооны хадгаламж, зээлийн бодлого, түүний хэрэгжилт, үйл ажиллагаа болон хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулсан тайлант жилийн санхүүгийн тайлан, ногдол ашиг хуваарилах эсэх болон тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хорооны тайлан, СЗХ болон эрх бүхий байгууллагын шалгалт, үзлэгийн дүнг хэлэлцдэг байх, шийдвэрийг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу гаргадаг, өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг бүрэн хангадаг, шийдвэрийг гишүүдэд шуурхай сурталчилдаг, гишүүд хэдийд ч танилцах бодит боломжийг хоршооны албан байранд бүрдүүлсэн болохыг тогтооно.</p> <p>Тухайлбал, хоршоо нь бүх гишүүдийн (төлөөлөгчдийн) хурлыг хуралдсан тухай тэмдэглэл, уг хурлын ирц, хурлаар хэрхэн шийдвэр гаргасан тухай болон ямар агуулгатай шийдвэр гарсан болохыг зарлалын самбар, танилцах дэвтэр, лавлагаа гэх мэтээр саадгүй танилцах боломжоор хангахыг ойлгоно.</p>

		Ээлжит бус хурлаар дээрх асуудлыг хэлэлцсэн бол уг хурлыг Хоршооны тухай хуульд заасны дагуу зарлан хуралдуулсан эсэхийг тогтооно.
1.6	<p>Хоршооны тэргүүлэгчээр ял шийтгэлгүй, эсхүл урьд өмнө дампуурсан хоршоонд ажиллаж байгаагүй, банк санхүү, эрх зүйн аль нэгэн чиглэлээр ажлын дадлага, туршлага бүхий гишүүдийг сонгосон байх, хоршооны тэргүүлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, ажил үүргийн хуваарийг нь тодорхой болгосон байх, үйл ажиллагаагаа бүх гишүүдийн хуралд тогтмол тайлагнаж, түүнийг нь дүгнэж, хариуцлага тооцдог тогтолцоог бүрдүүлж хэвшсэн байх, Тэргүүлэгчид нь хяналтын зөвлөл, зээлийн хороо болон эрсдэлийн хороо, гүйцэтгэх захиралтай нягт хамтран ажилладаг байх, Хоршооны дарга нь тэргүүлэгчдийн дарга байх, нэг гишүүн сонгуульт албан тушаал давхар хашихгүй мөн хоршооны өдөр тутмын буюу гүйцэтгэх ажлыг эрхлэхгүй байх;</p> <p>Хоршооны дарга нь тэргүүлэгчдийн дарга байх, нэг гишүүн сонгуульт албан тушаал давхар хашихгүй, хоршооны өдөр тутмын буюу гүйцэтгэх ажлыг эрхлэхгүй байх;</p>	<p>Цагдаагийн байгууллагийн ял шийтгэлгүй болохыг нотолсон тодорхойлолт, гааль, татварын байгууллага, санхүүгийн салбарт хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлийн талаарх тодорхойлолт, тэргүүлэгчдийн хувийн хэрэг, хоршооны дүрэм, бизнес төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь болон тэргүүлэгчдийн үйл ажиллагаатай холбоотой бусад баримт бичигт, бүх гишүүдийн хурлаар үйл ажиллагааны тайланг нь хэлэлцсэн байдал, газар дээрх хоршооны ажлын зохион байгуулалт зэргийг үндэслэн тогтооно. Шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас мэргэжил, мэргэшил, ур чадварын талаар тодорхойлолт болон бусад тодорхойлолтыг гаргуулж болно. Дээд боловсролын диплом болон холбогдох нотлох баримт бичгийг тулгалт хийх зарчмаар нотлоно, Гишүүд тэргүүлэгчээр сонгогдох боломжоор хангагдсан байх, тэргүүлэгчдийн үйл ажиллагаа нь тасралтгүй байх нөхцөлийг хангасан байх (тухайлбал, гишүүд тэргүүлэгчид өөрийн болон бусад гишүүдийн нэрийг чөлөөтэй санал болгодог уг саналыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцдэг, тэргүүлэгчдийг хэсэгчлэн эсхүл нөөц гишүүнтэйгээр сонгож үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангасан байгаа гэх мэт) Хоршооны үзэл баримтлал, үндсэн зарчмыг ойлгосон, түүний төлөө ажиллах хүсэл эрмэлзэлтэй, цаг зав гаргаж ажиллах боломжтой гишүүдийг сонгож чадсан эсэхийг тогтооно. Шаардлагатай бол мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл, тодорхойлолтыг гаргуулж болно. Тэргүүлэгчдийн анкетыг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон маягтын дагуу үнэн зөвөөр гаргасан эсэхийг тогтооно.</p>
1.7	Хоршооны дарга, гүйцэтгэх захирлаар ял шийтгэлгүй, эсхүл	Цагдаагийн байгууллагын ял шийтгэлгүй болохыг нотолсон тодорхойлолт, гааль,

	<p>урьд өмнө дампуурсан хоршоонд ажиллаж байгаагүй, аливаа санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй, санхүү эдийн засаг, хууль, нягтлан бодох бүртгэл, аудит, бизнесийн удирдлагын аль нэгэн чиглэлээр мэргэшсэн, энэхүү чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан хүнийг сонгосон байх, тэдгээрийн эрх, үүрэг, ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, ажлаа бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлд тайлагнаж, түүнийг нь дүгнэж, хариуцлага тооцдог тогтолцоог бүрдүүлж хэвшсэн байх;</p>	<p>татварын байгууллага, санхүүгийн салбарт хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлийн талаарх тодорхойлолт, хоршооны дарга, гүйцэтгэх захирлын хувийн хэрэг, хоршооны дүрэм, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь болон түүний үйл ажиллагаатай холбоотой бусад баримт бичигт, бүх гишүүдийн хурлаар үйл ажиллагааны тайланг нь хэлэлцсэн байдал, газар дээрх хоршооны ажлын зохион байгуулалт зэргийг үндэслэн тогтооно.</p> <p>Шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагаас ял шийтгэлгүй эсэх талаар, бусад байгууллагаас мэргэжил, мэргэшил, ур чадварын талаар тодорхойлолт гаргуулж болно.</p> <p>(мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл, тодорхойлолтыг гаргуулж болно)</p> <p>Хоршооны дарга, гүйцэтгэх захирлын анкетыг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон маягтын дагуу үнэн зөвөөр гаргадаг эсэхийг тогтооно.</p>
1.8	<p>Хяналтын зөвлөлийг холбогдох хууль, дүрмийн дагуу байгуулсан байх, санхүү, хууль зүйн мэдлэг, чадвар, дадлага, туршлага бүхий, ял шийтгэлгүй, урьд өмнө дампуурсан хоршоонд ажиллаж байгаагүй гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр сонгосон байх, хоршооны үйл ажиллагааг нь тогтмолжуулж, зөвлөл, түүний гишүүдийн эрх үүрэг, ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, ажлын үр дүнг бүх гишүүдийн хуралд тайлагнадаг байх, Хоршооны дарга, тэргүүлэгчид, гүйцэтгэх захиралд мэдээлдэг, түүнийг нь дүгнэж, хариуцлага тооцдог тогтолцоог бүрдүүлж хэвшсэн байх;</p>	<p>Цагдаагийн байгууллагийн ял шийтгэлгүй болохыг нотолсон тодорхойлолт, хяналтын зөвлөлийн гишүүдийн хувийн хэрэг, хоршооны дүрэм, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь болон түүний үйл ажиллагаатай холбоотой бусад баримт бичигт, бүх гишүүдийн хурлаар үйл ажиллагааны тайланг нь хэлэлцсэн байдал, газар дээрх хоршооны ажлын зохион байгуулалт зэргийг үндэслэн тогтооно.</p> <p>Шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагаас ял шийтгэлгүй эсэх талаар, бусад байгууллагаас мэргэжил, мэргэшил, ур чадварын талаар тодорхойлолт гаргуулж болно.</p> <p>(мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл, тодорхойлолтыг гаргуулж болно)</p> <p>Хоршооны хяналтын зөвлөлийн гишүүдийн анкетыг Санхүүгийн зохицуулах хорооноос</p>

		тогтоосон маягтын дагуу үнэн зөвөөр гаргадаг эсэхийг тогтооно.
1.9	Хоршооны зээлийн хороо болон эрсдэлийн хороог хуульд заасан журмын дагуу байгуулсан байх, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль зүйн мэдлэг, чадвар, дадлага туршлага бүхий, ял шийтгэлгүй, аливаа санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй, урьд өмнө дампуурсан хоршоонд ажиллаж байгаагүй гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, хороо, түүний гишүүдийн эрх үүрэг, ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, ажлын үр дүнг бүх гишүүдийн хурал, Хоршооны дарга, тэргүүлэгчид, хяналтын зөвлөлд тайлагнадаг, ажлыг нь дүгнэх, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлж хэвшсэн байх; Хадгаламж зээлийн мэргэжилтэн мөнгөний няравын албыг зэрэг хашихгүй байх;	Цагдаагийн байгууллагын ял шийтгэлгүй болохыг нотолсон тодорхойлолт, гааль, татварын байгууллага, санхүүгийн салбарт хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлийн талаарх тодорхойлолт, гишүүдийн хувийн хэрэг, хоршооны дүрэм, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь болон түүний үйл ажиллагаатай холбоотой бусад баримт бичиг, бүх гишүүдийн хурлаар үйл ажиллагааны тайланг нь хэлэлцсэн байдал, газар дээрх хоршооны ажлын зохион байгуулалт зэргийг үндэслэн тогтооно. Шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагаас ял шийтгэлгүй эсэх талаар болон бусад байгууллагаас мэргэжил, мэргэшил, ур чадварын талаар тодорхойлолт гаргуулж болно. Зээлийн хорооны гишүүдийн анкетыг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон маягтын дагуу үнэн зөвөөр гаргадаг эсэхийг тогтооно.
1.10	Хоршоонд шинээр гишүүн элсүүлэхдээ Хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу элсүүлсэн байх, шинээр гишүүн элсүүлэхэд улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийг, холбогдох бусад хүчин төгөлдөр мөрдөж буй журам, санхүүгийн байдлын талаарх мэдээлэлтэй танилцуулж, тэдгээрийг хүлээн зөвшөөрсөн эсэх талаар тодорхойлолт гаргуулдаг байх;	1.Шинээр гишүүн элсүүлэхэд Улсын бүртгэлд бүртгэгдсэн хүчин төгөлдөр дүрэм, дагаж мөрдөж буй холбогдох бусад заавар, журам, санхүүгийн байдлын талаарх мэдээлэлийг танилцуулж, тэдгээрийг хүлээн зөвшөөрсөн эсэх талаар тодорхойлолт гаргуулсан эсэхийг тогтооно, (Шинээр гишүүн элсүүлэхэд улсын бүртгэлд бүртгүүлсэн, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлж өгсөн хүчин төгөлдөр баримт бичиг танилцуулдаг эсэхийг хоршоо болон тэдгээрийн гишүүдийн тодорхойлолтоор нотлоно) 2.Гишүүний бүрэн эрх нь заавал оруулах хувь хөрөнгийг оруулснаар үүссэн эсэх (ямар нэг хэлбэр төдий хураамж, төлбөр авсны үндсэн дээр гишүүнчлэл олгодсон эсэх)-ийг тогтооно, 3.Бүрэн эрх нь үүсээгүй хүнд хоршооны хадгаламж, зээлийн үйлчилгээг үзүүлсэн эсэх зэргийг гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл,

		<p>гишүүдийн хувийн хэрэг дэх гишүүн элсэхэд гаргасан тодорхойлолт, шинээр гишүүн элсэхэд оруулах хувь хөрөнгө, захиргааны зардлаас өөр бусад гишүүний эрх олгох хураамж авдаг эсэхийг хоршооны санхүүгийн тайлан болон гишүүдээс өгсөн тодруулга зэргийг үндэслэн тогтооно.</p> <p>(Гишүүдээс түүвэрлэн лавлаж болно.)</p> <p>4.Хоршооны гишүүнээр 16-аас доош насны иргэнийг элсүүлээгүй болохыг болон зөвхөн тухайн хоршооны насанд хүрсэн гишүүний 16-аас доош насны төрсөн, үрчилсэн хүүхдийн нэр дээр хадгаламж нээсэн, тэдгээрийн нэр дээр зээл олгоогүй болохыг гишүүдийн бүртгэл болон холбогдох санхүүгийн баримтад үндэслэн тогтооно.</p>
1.11	<p>Хоршооны гишүүдийн бүртгэлийг Хоршооны тухай хуулийн 29.2-т заасны дагуу хөтөлсөн байх, гишүүдийн бүртгэлд гишүүдийн гарын үсгийн баталгаажуулсан хуулбарыг хавсаргадаг байх, бүртгэлд орсон өөрчлөлтийг Хоршооны тухай хуулийн 11.4-т заасны дагуу бүртгэх байгууллагад мэдэгдэж бүртгүүлдэг байх;</p>	<p>1.Гишүүдийн бүртгэл нь хуульд заасан асуудлыг бүрэн агуулж буй эсэх, хоршооны үйлчилгээнд хамрагдсан гишүүд хоршооны гишүүдийн бүртгэлд бүрэн бүртгэгдсэн эсэх, тэдгээрийн гарын үсгийн батлагаажуулсан хувь нь үйлчилгээ авсан тухай холбогдох баримт бичигт заасан гарын үсэгтэй тохирч буй эсэхийг тогтооно,</p> <p>2.Бүртгэл хөтлөлтийн байдал, бүртгэлд орсон өөрчлөлтийг бүртгэх байгууллагад тогтоосон хугацаанд багтаан мэдэгддэг эсэхийг тогтооно,</p> <p>3.Бүртгэлээс хасагдсан гишүүдэд үйлчилгээ үзүүлж буй эсэх зэргийг тогтооно.</p> <p>(нийт гишүүдийн тоо, иргэний үнэмлэх, регистрын дугаар, холбоо барих хаягийг үнэн зөв тусгасан байдал)</p>
1.12	<p>Хоршооны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлтэй гишүүд хэдийд ч танилцах боломжийг бүрдүүлсэн байх, гишүүдээс гаргасан үндэслэл бүхий санал, шүүмжлэлийг хүлээн авч, тухай бүр шуурхай шийдвэрлэж хариу өгч, үр дүнг тэргүүлэгчдийн хурал, бүх гишүүдийн хуралд танилцуулдаг байх горимыг тогтоон мөрдүүлж хэвшсэн байх;</p>	<p>1. Гишүүдээс гаргасан санал, шүүмжлэлийг хүлээн авч, тухай бүр шийдвэрлэн хариу өгдөг, үр дүнг тэргүүлэгчдийн хурал, бүх гишүүдийн хуралд танилцуулдаг зарчмыг хоршооны дүрэм, журам, тэмдэглэл гэх мэт баримтыг үндэслэн тогтооно,</p> <p>2.Хоршооны албан байран дахь ажлын зохион байгуулалт, гишүүдээс (зарим гишүүдээс сонголт хийх зарчмаар лавлаж болно) өгсөн лавлагаа, асуулгын хариу зэргийг үндэслэн тогтооно.</p> <p>Улсын бүртгэлд бүртгүүлсэн, тусгай зөвшөөрөл олгоход Хороогоор хянуулж зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр баримт бичиг болон хяналт шалгалтын тайланг гишүүдэд хэрхэн саадгүй, шударгаар танилцуулдаг</p>

		эсэхийг анхаарч тогтооно.
1.13	Хорооны зүгээс тавьсан шаардлага, мэдэгдлийг тогтоосон хугацаанд түргэн шуурхай гүйцэтгэж, хууль бус, эрсдэл бүхий үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр Хороотой хамтарч ажилладаг байх;	1.Хорооны зүгээс тавьсан шаардлага, Улсын байцаагчийн мэдэгдлийг тогтоосон хугацаанд биелүүлж, тайлагнасан байдлыг баримтад үндэслэн тогтооно.
1.14	Үйл ажиллагаа явуулах ажлын байртай, албан ёсны хаягтай байх;	Оршин байх байнгын хаяг бүхий ажлын байртай байх, байнгын емейл хаяг, телефон утасны дугаар, факсны дугаартай, эдгээр мэдээлэл өөрчлөгдсөн нөхцөлд гишүүд болон Хороонд тухай бүр мэдээлдэг эсэхийг тогтооно.
1.15	Мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг ханган ажилладаг байх.	Холбогдох баримт бичигт үндэслэн тогтооно. Шаардлагатай бол цагдаагийн байгууллага, Монголбанк зэрэг холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авч болно.
2. Санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой, эрсдэлгүй байдлыг хангах ажиллагааны хүрээнд:		
2.1	Хоршоо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагааг эрсдэлгүй, алдагдалгүй, явуулах чиглэлээр үндэслэл бүхий бизнес төлөвлөгөөг боловсруулсан байх, уг төлөвлөгөөг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгодог байх;	Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 10 дугаар сарын ...-ны өдрийн 52 тоот тогтоолын ... дугаар хавсралтаар Хоршооны бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийн дагуу боловсруулж, бүх гишүүдийн хурлаар баталсан бизнес төлөвлөгөө нь үндэслэл болно.
2.2	Иргэний хуулийн 33.2-т заасны дагуу ашгийн бус зарчмыг холбогдох төлөвлөгөө, үйл ажиллагаандаа тусгаж, мөрдлөгө болгодог байх; (Хадгаламжид төлөх хүү, олгосон зээлийн хүүгийн хэмжээ нь хоршооны эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдоогүй байх)	1.Зээлийн үйл ажиллагаанаас олох орлогыг урьдчилан тооцож уг орлогыг гишүүдээс төвлөрүүлэх хадгаламжийг нэмэгдүүлэх, олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлж байгаа буюу гишүүдээс хоршоонд оруулсан хөрөнгийг нэмэгдүүлсэн болон ногдол ашиг хуваарилсан эсэхийг санхүүгийн тайлан болон холбогдох тайлан мэдээтэй тулгах замаар тогтооно, 2.Хадгаламж, зээлийн хүүгийн түвшин нь санхүүгийн салбарын зах зээлийн хүүгийн дундажаас илүүгүй, ашгийн бус зарчмаар тогтоогдсоныг хоршооны төлөвлөгөө, санхүүгийн тайлан, мэдээнээс тогтооно.
2.3	Хоршооны нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан	1.Санхүүгийн баримт бичгийг нэг, хоёрдугаар гарын үсгээр баталгаажуулдаг эсэх, санхүүгийн жил дууссанаас хойш 6

	<p>бодох бүртгэлийн олон улсын зарчимд нийцсэн байх, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сар бүр хангаж ажилладаг байх, хангахгүй болсон буюу хангахгүй болж болзошгүй тохиолдолд энэ талаар тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон эрсдэлийн хороонд даруй мэдэгддэг байх, тэдгээр нь шуурхай арга хэмжээ авч уг нөхцөл байдлыг дараа сарын дотор залруулах боломжгүй бол бүх гишүүдийн хурлаар асуудлыг хэлэлцүүлдэг журмыг тогтоон хэвшүүлсэн байх, үүнтэй холбоотой мэдээлэлтэй гишүүд хэдийд ч танилцах боломжийг бүрдүүлсэн байх;</p>	<p>сарын дотор бүх гишүүдийн хуралд хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг танилцуулж, батлуулдаг эсэх, санхүү бүртгэлийн заавал хөтлөх дэлгэрэнгүй болон хураангуй тайлан бүртгэлийг хөтөлдөг эсэх зэргийг холбогдох баримтад үндэслэн тогтооно.</p> <p>2.Хоршооны хөрөнгийн зохистой удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлсэн эсэх, Хоршооны эд хөрөнгийг захиран зарцуулах журмыг хоршооны дүрэмд тусгасан эсэх, уг заалтын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа эсэх болон гишүүдэд хэрхэн тайлагнаж, ашгаас хуваарилах хувь хөрөнгийг хэрхэн хуваарьладаг эсэхийг дүрэм, холбогдох журам болон баримт материалд үндэслэн тогтооно.</p> <p>3.Үйл ажиллагааны зохистой харьцааны үзүүлэлтийг хангахгүй болсон буюу хангахгүй болж болзошгүй тохиолдолд тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороонд даруй мэдэгддэг зарчмыг хоршооны дүрэм, журамд оруулсан эсэхийг тогтооно,</p> <p>4.Хоршооны тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, холбогдох ажилтан нар нь шуурхай арга хэмжээ авч уг нөхцөл байдлыг сарын дотор залруулах боломжгүй тохиолдол гарсан бол бүх гишүүдийн хурлаар асуудлыг хэлэлцүүлсэн эсэхийг тогтооно,</p> <p>5.Холбогдох мэдээлэлтэй гишүүд хэдийд ч танилцах боломжийг бүрдүүлсэн эсэхийг тогтооно,</p> <p>6.Санхүүгийн давхар хяналтын арга, хэлбэр, ажлын зохион байгуулалт, аливаа эрсдэл гарч болзошгүй тохиолдолд мэдээллийг тэргүүлэгчид, хяналтын зөвлөлд хэрхэн мэдэгддэг, тэдгээр нь ямар арга хэмжээ авч байсан эсэхийг хурлын тэмдэглэл, шийдвэртэй танилцаж, энэ асуудлаар гишүүдэд мэдээлэл хэрхэн хүргэдэг талаар гишүүдээс өгсөн мэдээлэл, тэмдэглэл зэрэгт үндэслэн тогтооно.</p>
2.4	<p>Хоршооны тухай хуулийн 49.1.3 дахь заалтыг ханган ажиллахдаа хадгаламж авах, зээл олгох үйл ажиллагааг зөвхөн гишүүдийнхээ хүрээнд явуулдаг байх, гишүүдээс төвлөрүүлсэн хадгаламж, хоршооны өөрийн</p>	<p>1.Гишүүдээс төвлөрүүлсэн хадгаламж, хоршооны өөрийн хөрөнгөөс зээлийн эх үүсвэрт ашиглах хөрөнгийг хоршооны бусад хөрөнгөөс тусгаарлан, тусгаарласан хөрөнгийг зээлийн үйл ажиллагаанаас бусад төрөл (үл хөдлөх хөрөнгө, авто машин худалдаж авах, хоршооны ажилчдын цалин,</p>

	<p>хөрөнгөөс зээлийн эх үүсвэрт ашиглах хөрөнгийг хоршооны бусад хөрөнгөөс тусгаарлан, тусгаарласан хөрөнгийг хадгаламж, зээлийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаанд зарцуулдаггүй байх; (“гишүүдийн хүрээнд хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх” гэдэгт Хоршооны тухай хуулийн 48².6-д заасны дагуу хоршооны гишүүний насанд хүрээгүй хүүхдийн нэр дээр нээлгэсэн хадгаламж хамаарахгүй)</p>	<p>хөлс тавьж олгох, бичиг хэргийн зардалд гаргах гэх мэт)-ийн үйл ажиллагаанд зарцуулаагүй байгааг хоршооны дүрэм, журам болон санхүүгийн баримтад тулгуулан тогтооно.</p> <p>2.Хоршооны гишүүдээс төвлөрүүлэх хувь хөрөнгийн дээд, доод хэмжээ, хэлбэр, буцаан олгох нөхцөл, шаардлага, үүнтэй холбоотой хүлээх үүрэг, хариуцлага зэргийг нарийвчлан тусгасан эсэхийг дүрэм, холбогдох журам, санхүүгийн баримтад үндэслэн тогтооно.</p>
2.5	<p>Ямар нэг хэлбэр, аргаар гишүүн бус этгээдээс хадгаламж авах, гишүүн бус этгээдэд зээл олгодоггүй байх (тухайлбал, гишүүний эхнэр, нөхөр, аав, ээж, ах, дүү, төрөл садангийн болон найз зэрэг тухайн гишүүний насанд хүрээгүй хүүхдийн нэр дээр хадгаламж нээхээс бусад холбоотой хүмүүс, эсхүл гишүүнээр элсээгүй буюу гишүүний эрх нь нээгдээгүй иргэн, хуулийн этгээд), олгох боломж, нөхцөлийг таслан зогсоосон байх;</p>	<p>Хоршооны дүрэм, холбогдох журмууд болон санхүүгийн баримтын шалгалт, байгуулсан гэрээ хэлцэлтэй танилцах замаар тогтооно.</p>
2.6	<p>Нэг гишүүнээс авч болох хадгаламж, нэг гишүүнд олгож болох зээлийн хэмжээг (энд “нэг гишүүнээс авч болох хадгаламж, олгож болох зээл”-ийн хэмжээг тухайн нэг гишүүнд нэг буюу хэд хэдэн хэлцлийн үндсэн дээр авсан хадгаламж, эсхүл олгосон нийт зээлийн хэмжээгээр тооцно) тухайн хоршооны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нөлөөлөхөөргүй хэмжээгээр тогтоож, уг хэмжээнээс хэтэрсэн хадгаламжийг нэг гишүүнээс авдаггүй буюу нэг гишүүнд зээл олгодоггүй байх, гишүүн хоршоонд оруулсан хөрөнгийг барьцаалан зээл авахгүй байх, гишүүн хадгаламжийн дансаа</p>	<p>Нэг гишүүнд олгох зээлийн хэмжээ, зээлийн төрөл, нэг гишүүнд болон нэгдмэл сонирхол бүхий гишүүдэд олгох зээлийн дээд хэмжээ, нөхцөл, шаардлага, хугацаа хэтэрсэн зээл бүхий гишүүнд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан дүрэм, журам, заавар байгаа эсэхийг тогтооно.</p> <p>Хоршооны дүрэм, хадгаламжийн болон зээлийн журмууд, бизнес төлөвлөгөө, санхүүгийн баримт бичиг, байгуулсан гэрээ хэлцлийг тухайн үеийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлттэй тулгалт хийж, баримтаар нотлон тогтооно.</p> <p>Дүрэмд гишүүдээс хадгаламж төвлөрүүлэх доод, дээд хэмжээ, түүнийг буцааж олгох нөхцөл, шаардлага, хязгаарлалт, хариуцлагыг тогтоосон эсэх, тогтоосон хэмжээ, хувь нь үндэслэлтэй эсэхийг тогтооно.</p> <p>Зээлийн үйлчилгээ нь зөвхөн тухайн</p>

	барьцаалан зээл авсан бол нийт үүргийн гүйцэтгэлийн хэмжээгээр уг хадгаламжийн дансны гүйлгээг хязгаарлаж байх;	хоршооны гишүүний хувийн эдийн засгийн хэрэгцээг хангах зориулалттай (гишүүнээр дамжуулж ямар нэг хуулийн этгээдэд хөрөнгө оруулах, хувийн хэрэгцээний барилга, орон сууц барихаар их хэмжээний, хоршооны хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, зохистой харьцааны үзүүлэлтийг хангахгүй болгож болох зээлийг олгодоггүй эсэхийг)-гаар тусгагдсан эсэхийг дүрэм, журам, санхүүгийн баримтад үндэслэн тогтооно. Үүний тулд хоршоо нь 20 том зээлдэгч, хадгаламж эзэмшигчдийн талаарх мэдээллийг (овог, нэр, иргэний үнэмлэх, регистрийн дугаар, холбоо барих хаяг, хадгаламж авсан, зээл олгосон огноо, гэрээ дуусах огноо, хадгаламжийн болон зээлийн хүүгийн хувь, төлсөн хүүгийн хэмжээ, барьцаа хөрөнгө, зээлийн эцсийн үлдэгдэл, зээлийн чанар зэрэг) ирүүлнэ.
2.7	Тодорхой гишүүнд олгох зээл нь түүний хадгалуулсан хөрөнгийн хэмжээнээс давсан бол уг давсан хэмжээнд барьцаа, эсхүл батлан даалтын гэрээ байгуулдаг байх;	Хоршооны дүрэм, хадгаламжийн болон зээлийн журмууд, санхүүгийн баримт бичиг, байгуулсан гэрээ хэлцлийг тухайн үеийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлттэй тулгалт хийж, баримтад тулгуурлан тогтооно.
2.8	Гаднаас оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тухайн хоршооны санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлөхөөргүй хэмжээгээр бүх гишүүдийн хурал, эсхүл бүх гишүүдийн хурлын эрх олгосноор тэргүүлэгчдийн хурлаас тогтоосон байх, уг хязгаарыг чанд баримтлан ажилладаг байх;	Хоршооны дүрэм, хадгаламжийн болон зээлийн журмууд, бизнес төлөвлөгөө, санхүүгийн баримт бичиг, байгуулсан гэрээ хэлцлийг тухайн үеийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлттэй тулгалт хийж, уг асуудлаар гаргасан холбогдох албан тушаалтан, зөвлөл, хорооны шийдвэрийн үндэслэлд тухайн хоршооны санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх эсэх асуудлын харгалзсан эсэхийг шалгаж тодруулсны үндсэн дээр тогтооно.
2.9	Санхүүгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрхэлдэг байх, зээлийн багцыг холбогдох журмын дагуу ангилж, зээлийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй алдагдлыг нөхөх эрсдэлийн санг бүрэн хэмжээнд байгуулдаг байх, зээлийн эргэн төлөлтөд өдөр тутам хяналт тавьж, шуурхай төлүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх бүтэц, журмыг	Хоршооны дүрэм, хадгаламжийн болон зээлийн журмууд, бизнес төлөвлөгөө, санхүүгийн баримт бичиг, байгуулсан гэрээ хэлцлийн хэрэгжилт, зээлийн чанарыг Хорооноос баталсан журмын дагуу эрсдэлийн санг зохих хэмжээгээр тухай бүр байгуулж ажиллаж байсан эсэхийг тогтооно. Хоршооны дүрэм болон бусад холбогдох журамд тусгасан эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмын агуулга нь холбогдох хууль дүрэм, журамд хэрхэн нийцэж буйг болон түүнийг хэрхэн хэрэгжүүлдэг эсэхийг мөн шалгаж тогтооно.

	боловсруулан баталсан байх;	
2.10	Үйл ажиллагаанаас учирч болзошгүй алдагдал буюу эрсдэлийг даатгуулсан байх;	Хоршооны дүрэм, хадгаламжийн болон зээлийн журмууд, бизнес төлөвлөгөө, санхүүгийн баримт бичиг, байгуулсан гэрээ хэлцэлтэй танилцах замаар тогтооно.
2.11	Улирал бүр санхүүгийн тайлан, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг дараа сарын 10-ны дотор, хөндлөнгийн аудитын баталгаажуулсан санхүүгийн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор тус тус Хороонд ирүүлсэн байх, гишүүд тэдгээр тайлантай хэдийд ч танилцах боломжийг бүрдүүлсэн байх;	Тухай бүр Хороонд ирүүлж байсан албан тоот, санхүүгийн тайлангуудын хувьтай тулгалт хийх замаар тогтооно.
2.12	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохицуулалт үйлчилгээний хөлсийг тухай бүр хугацаанд нь төлдөг байх.	Тухай бүр Хороонд төлж байсан баримтад үндэслэн тогтооно.
3. Нөхцөл, шаардлага хангасан болохыг нотлох баримт бичгийн хүрээнд:		
3.1	Албан бичгийн шаардлагыг хангасан, зөрчилгүй, үг үсгийн алдаагүй байх;	Хоршооны дүрэм, холбогдох журмууд, бизнес төлөвлөгөө, ирүүлсэн албан тоот, өргөдөл болон хоршооны үйл ажиллагааны явцад гарсан бүх баримт бичигт хамаарна.
3.2	Бүрэн бүрдэл бүхий шаардлага хангасан баримт бичгийг нэгтгэж, нүүр бүрээр дугаарлаж, товъёолсон байх;	Хороонд тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн өргөдөл, түүний хавсралт баримт болон Хороонд ирүүлж буй баримт бичигт хамаарна. Хоршоо нь өөрийн оршин байх хаяг, холбоо барих утас, факсны дугаар, e-майл хаягийг ирүүлнэ. Эдгээр хаягийн өөрчлөлтийг Хороонд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй ба зохих хугацааны дотор мэдэгдээгүй, эсхүл буруу мэдээлсэн зэргээс үүсэх хариуцлагыг Хороо хариуцахгүй бөгөөд бүрэн бүрдэл бүхий шаардлага хангасан материалыг хүлээлгэн өгсөн өдрөөр өргөдөл хүлээн авсанд тооцно. (техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны тодорхойлолт, хоршооны удирдлага, ажилчдын анкет,

		тодорхойлолт, хувь нийлүүлэгчдийн бүртгэл, 20 том хадгаламж эзэмшигч, зээлдэгчдийн талаарх судалгаа гэх мэт)
3.3	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хоршооны дүрэм, хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны журмын улсын бүртгэлд бүртгэгдсэн хүчин төгөлдөр хувийг нотариатаар гэрчлүүлсэн байх;	Зохих журмын дагуу нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг үндэслэн тогтооно. Шаардлагатай гэж үзвэл гэрчилгээний хүчин төгөлдөр эсэх асуудлаар бүртгэлийн байгууллагад хандаж тодорхойлолт гаргуулж болно.
3.4	Бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчид, хоршооны дарга, гүйцэтгэх захирал, зээлийн хорооны шийдвэрийг баталгаажуулсан байх, хуулбарлан ирүүлэх бол хуулбар үнэн болохыг гэрчлүүлсэн байх;	Хууль тогтоомж, журамд заасны дагуу бүх гишүүдийн хурлын шийдвэр, тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурсан байх, уг гарын үсэг бүхий шийдвэрийг гишүүдийн бүртгэл дэх гишүүдийн гарын үсгийн баталгаажуулсан хувьтай тулгах замаар хүчин төгөлдөр эсэхийг тогтооно.
3.5	Их хэмжээний хэлцлийн талаар гаргасан шийдвэрийг тэмдэглэлийн хамтаар ирүүлэх, тэдгээрийг хуулбарлан ирүүлэх бол хуулбар үнэн болохыг гэрчлүүлсэн байх;	Хоршооны активын 10 хувиас дээш хэмжээний хэлцлийг байгуулах эсэх асуудлыг бүх гишүүдийн хурал эсхүл тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн байх, тавигдах нөхцөл шаардлагыг тодорхой хэлэлцсэн байх, үүргийн гүйцэтгэлийн баталгааг заавал хангасан байх зэргийг байгуулсан гэрээ хэлцэл, уг асуудлаар гаргасан шийдвэрийг шалгах замаар тогтооно.
3.6	Санхүүгийн тайлан мэдээг тогтоосон хэлбэр, загварын загуу үнэн зөвөөр гаргаж ирүүлэх.	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын дагуу шалгаж тогтооно.

---oOo---

ХОРШОО ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,
Засгийн газрын IV байр
Бага тойруу-6,
Улаанбаатар-46,
Монгол Улс.

Хэнээс:

(*өргөдөл гаргагчийн овог, нэр, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг*)

/ хоршооны нэр/

Хоршооны хөрөнгийн хэлбэр:

(*эх үүсвэрийн бүтэц бүрдэл*)

Үүсгэн байгуулагдсан хэлбэр, сонирхлын нэгдмэл хүрээ:

Тус хоршоо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх шийдвэрийг 200... оны ... дугаар сарын ...-ны өдөр хуралдсан бүх гишүүдийн хурлын ... тоот тогтоолоор гаргасан болно.

Тус хоршоонд дараах овог, нэр бүхий гишүүд (дундын хоршооны тухайд хуулийн этгээд) тус хоршоонд дор дурдсан хувь хөрөнгийг (мөнгөн хөрөнгө, эд хөрөнгө, ажил үйлчилгээ, оюуны өмчийг) оруулахаар шийдвэрлэсэн болно.

Д/д	Овог, нэр <i>/Хуулийн этгээдийн нэр/</i>	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар <i>/Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/</i>	Хаяг	Хоршоонд оруулсан хувь хөрөнгө бусад <i>(мянган.төгрөгөөр)</i>

Жич: Ажил үйлчилгээ оюуны өмчийг үнэлж хувь хөрөнгө оруулсан бол уг хөрөнгийг хэрхэн үнэлж, хэдэн төгрөгөөр тооцсон тухай тайлбар хавсаргах шаардлагатай

Хоршооны гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн эх үүсвэр нь тэдгээрийн хууль ёсны хувийн өмчлөл дэх хөрөнгө болохыг холбогдох баримтад үндэслэн тодорхойлж байна.

Жич: Холбогдох санхүүгийн баримт, тухайн гишүүний тодорхойлолтыг хавсаргах шаардлагатай

Хоршооны тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороонд дараах нэр бүхий, шаардлага хангасан хүмүүс ажиллах болно. Үүнд:

Д/д	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Хоршоонд эрхлэх албан тушаал

Өргөдөлд хавсаргасан баримт бичгийн жагсаалт:

1. Хоршооны үүсгэн байгуулах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр хуудас ...
2. Хоршооны дүрэм (бүх гишүүдийн хурлаар батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн) хуудас ...
3. Эхлэлтийн тайлан баланс хуудас ...
4. Үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах хадгаламжийн болон зээлийн заавар, журам хуудас ...
5. Бусад

Жич: Энэ мэтээр хавсаргасан баримт бичгийг дугаарлан хуудасны тооны хамтаар жагсааж бичнэ

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж буйг тогтооход шаардлагатай баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр, журам, зааврын дагуу үнэн зөв бүрдүүж хүргүүлсэн ба бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг буруу, ташаа, хуурамч баримт, мэдээлэл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Энэхүү өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авч, зохих журмын дагуу хянаж, шийдвэрлэж өгөхийг хүсье.

Тус Хоршоо нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр, тавьсан шаардлага, мэдэгдэл, үүрэг даалгаврыг тухай бүр шуурхай биелүүлж ажиллахаа үүгээр баталж байна.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

..... Хоршоог төлөөлж

/...../
/овог, нэр/

/...../
/гарын үсэг/

Дундын хоршоо бол:
/тамга тэмдэг/

.....
/хуулийн этгээдийн нэр/
/...../
/гарын үсэг/

.....
/албан тушаал/
/...../
/овог, нэр/

ХОРШООНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

1. Бизнес төлөвлөгөө гэдэг нь Хоршооны стратеги, зорилтыг тодорхойлж, хоршооны үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, тэргүүлэгчдийн ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

2. Хоршоо нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд дараах асуудлуудыг заавал тусгасан байна. Үүнд:

2.1 Хоршооны үйл ажиллагаа эрхлэх зорилго, баримтлах бодлого, хэтийн төлөв байдал;

2.2. Хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро түвшин дэх боломжит нөхцөлүүд; /хоршооны эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн/

2.3. Хоршооны тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 2 жилийн төсөөлөл;

2.4. Актив, пассивын бүтэц, хэмжээ түүний удирдлагыг сайжруулах төлөвлөгөө, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлүүд, энэ талаар баримтлах бодлого;

2.5. Үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ;

3. Бизнес төлөвлөгөөг хоршооны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 2-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна.

4. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Нүүр хуудас

Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:

- Хоршооны нэр, хаяг
- Бизнес төлөвлөгөөний нэр
- Боловсруулсан огноо
- Зохиогчийн нэр, хаяг
- Зохиогчийн тэмдэглэл
- Хоршооны удирдлагын нэр, хаяг

I. Гүйцэтгэлийн хураангуй

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэг нь хоршооны гишүүний ямар хэрэгцээг, ямар арга замаар хангах тухай тодорхойлолт юм.

Зорилт гэдэг нь эрхэм зорилтод хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэмжигдэхүйц бодитой үр дүн буюу хүрэх цэг юм.

II. Бизнес танилцуулга

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн Хоршооны нэр, хаяг, өсөж хөгжиж ирсэн түүх, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхэлж байгаа үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавхи ба бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, зээлийг эргэж төлөх хугацаа, үр ашиг, борлуулалтын орлого зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Бизнес ба түүний түүх
- Зах зээлийн нөхцөл төлөв байдал
- Одоо явуулж байгаа үйл ажиллагаа
- Удирдлага боловсон, хүчин
- Санхүүгийн байдал төлөв
- Бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго

III. Менежментийн төлөвлөгөө

Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээ гэсэн асуудлуудыг багтааж оруулна.

Удирдах баг: Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт тэргүүлэгчид нь хууль болон банк санхүү, менежментийн чиглэлээр хэр мэргэшсэн, бие биенээ орлох чадвар нь ямар болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр зэрэг хангасан байдал болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан байдал зэргийг харуулах хэрэгтэй. Тэргүүлэгчид болон мэргэжилтэн (хуулийн зөвлөх г.м.), тэргүүлэх ажилтны (салбаруудын удирдлага г.м.) дадлага, туршлага, тухайн салбарт ажилласан байдал, үүрэг хариуцлага зэрэг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл бүхий намтрыг бизнес төлөвлөгөөндөө хавсаргах шаардлагатай. Түүнчлэн удирдах багийн гишүүн бүрийн эрх үүрэг хариуцлагыг нягт тогтоож, хэн нь хэнд захирагддаг, хэн эцсийн шийдвэр гаргадгийг зааж байгууллагын дүрэмд оруулан баталгаажуулж, төлөвлөгөөндөө хавсаргах зэрэг болно.

Зохион байгуулалтын бүтэц: Тэргүүлэгчид дор зохион байгуулалтын шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай бүтцийг тогтоох нь чухал. Цөөн хүнтэй хамт олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндэс зарчим нь нэг удирдлагатай байх, ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдагч мэдээллээр сайн хангагддаг байх,

ажиллагсдын ажлын үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байх явдал болно. Энэхүү зарчмыг баримтлан зохион байгуулалтын бүтцээ тогтоож бизнес төлөвлөгөөндөө оруулна.

Боловсон хүчин: Энэ хэсэгт шаардагдлагатай мэргэжлийн боловсон хүчин тэдгээрийн тоо түүнчлэн мэргэжил эзэмшүүлэх эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтын асуудлуудыг төлөвлөх болно.

Нийт ажиллагсад болон шаардагдлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажиллагсдын тоо түүнчлэн нийт ажиллагсдын сар, жилийн цалингийн хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө.

Сургалтанд зориулсан зардал хэдийгээр гаднаас нь харахад ашиггүй мэт боловч үр ашгаа зүй ёсоор өгдөг гэдгийг анхаарвал зохистой.

IV. Санхүүгийн төлөвлөгөө

Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно. Үүнд :

- Нийт орлогын тооцоо
- Үйл ажиллагааны урсгал зардлын тооцоо
- Алдагдалгүй ажиллагааны тооцоо
- Мөнгөн урсгалын тооцоо гэх мэт .

Ү. Эрсдэлийн шинжилгээ

6.1.Эрсдэлийн төрлүүд:

Хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд үндсэн 5 төрлийн эрсдэлийг тооцоолоход болно.

1. Санхүүгийн болон зээлийн
2. Техник, тоног төхөөрөмж, бүртгэлийн программын;
3. Хүний хүчин зүйлийн
4. Хууль зүйн болон гэнэтийн гамшигийн
5. Бусад

6.2.Эрсдэлийг багасгах боломжууд

Эдгээр дурдсан эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ? Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих нь зүйтэй. Дараа нь даатгалд хамруулж болох эрсдэлийг ангилж ямар нөхцөлөөр аль даатгалын компанитай гэрээ хийхээ тодорхойлж бич. Харин даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дүнд Хоршооны ашигт ажиллагаа хэрхэн хадгалагдаж үлдэхийг төлөвлөсөн үр дүнтэй жишиж харьцуулаарай.

**ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

Хоршооны үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Д/д	Техник, тоног төхөөрөмжийн төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээслэсэн, гишүүнээс оруулсан алин болох	Тоо ширхэг

Хоршоо нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютерээс гадна нягтлан бодох бүртгэлийн
(программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, (цаашид зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий) -г (худалдан авсан, худалдан авах гэж байгаа, гишүүдээс оруулсан эсхүл гэрээ хийсэн байгаа аль нь эсэхийг бичих) бөгөөд өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерийн
. (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ ашиглах болно.

Хоршоо нь үйл ажиллагаа явуулах байрыг:

- худалдан авсан
- түрээслэсэн

бөгөөд энэхүү байр нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйлчилгээг эрхлэхэд тохиромжтой, аюулгүй байдлын хувьд бүрэн хамгаалагдсан болно.

- Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ
- Түрээслэсэн байрны түрээсийн гэрээ
- Харуул хамгаалалтыг хэрхэн шийдвэрлэх, шийдвэрлэсэн хуулбарыг хавсаргав.

..... Хоршоог төлөөлж

.....
/албан тушаал/

..... /

..... /
/овог, нэр/

..... /гарын үсэг/

**ХОРШООНЫ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ТЭРГҮҮЛЭГЧИД, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ,
ЗЭЭЛИЙН ХОРОО БОЛОН ЭРСДЭЛИЙН ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮДИЙН
ТОДОРХОЙЛОЛТ ЗАГВАР**

А. Хоршоотой ямар холбоотой болохыг тэмдэглэнэ үү.

- | | |
|---|--------------------------|
| 1. Үүсгэн байгуулагч | <input type="checkbox"/> |
| 2. Нийт өөрийн хөрөнгийн 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч | <input type="checkbox"/> |
| 3. Хоршооны тэргүүлэгч | |
| Тэргүүлэгчдийн дарга (Хоршооны дарга) | <input type="checkbox"/> |
| Хяналтын зөвлөлийн дарга | <input type="checkbox"/> |
| Хяналтын болон тэргүүлэгч гишүүн | <input type="checkbox"/> |
| 4. Дотоод хяналтын албаны дарга (. бусад) | <input type="checkbox"/> |
| 5. Зээлийн хороо болон Эрсдэлийн хорооны дарга | <input type="checkbox"/> |
| гишүүн | <input type="checkbox"/> |

Б. Хоршоонд оруулсан хувь хөрөнгийн хэмжээ: *(Ажил үйлчилгээ оюуны өмчийг үнэлж хувь хөрөнгө оруулсан бол уг хөрөнгийг хэрхэн үнэлж, хэдэн төгрөгөөр тооцсон тухай тайлбарыг тодорхой бичих)*

Бэлэн мөнгөөр

Эд хөрөнгөөр


Бусад

..... /тоогоор/ /үсгээр/ /төгрөг/

Тайлбар:

В. Үүсгэн байгуулагч нь дараах мэдээллийг үнэн зөв бичнэ:

- Овог, нэр:
- Төрсөн он, сар, өдөр:
- Иргэний харьяалал:
- Гэрийн хаяг:
- Иргэний үнэмлэхийн дугаар:




ХОРШООНЫ БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТЫН ЗАГВАР

1. Хоршооны боловсон хүчин нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- овог, нэр:
- эрхлэх албан тушаал:
- төрсөн он, сар, өдөр:
- иргэний харьяалал:
- гэрийн хаяг:
- утасны дугаар:
- иргэний үнэмлэхийн дугаар:
- регистрийн дугаар:
- одоо эрхэлж байгаа ажил:

- хугацаа:
- хаяг:

- Боловсролын талаар (*Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ*)



Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар:

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Шалтгаан

2. Боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

..... Хоршоог төлөөлж

/...../
 /албан тушаал/

/...../
 /гарын үсэг/